

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/44/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРХУСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Залруулсан алдаа	21
5.2 Албан шаардлага	21
5.4 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	23
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	15
Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	20

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/150
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газарт элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 589,324.0 мянган төгрөгийн өртөгтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Саммит компьютер технологи ХХК-иас 24,147.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа босго үнэд багтаан хувааж шилжүүлэн тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

G/Архив/Alban bichig 2023/ A4

19020283

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,661,668.44	68,453,268.44
35	БАРАА МАТЕРИАЛ	41,661,668.44	68,453,268.44
351	Түүхий эд материал	92,066.44	92,066.44
35110	Тусгай зориулалттай материал	92,066.44	92,066.44
354	Хангамжийн материал	33,769,602.00	60,561,202.00
35410	Бичиг хэргийн материал	1,915,664.00	1,915,664.00
35420	Аж ахуйн материал	8,539,288.00	8,539,288.00
35430	Сэлбэг хэрэгсэл	160,000.00	2,760,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,015,000.00	6,508,600.00
35470	Бусад хангамжийн материал	18,139,650.00	40,837,650.00
35600	Мал амьтад	7,800,000.00	7,800,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,339,948,545.89	1,588,060,453.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,339,948,545.89	1,588,060,453.57
392	Биет хөрөнгө	1,105,119,545.89	1,353,484,953.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,184,793,143.00	1,248,770,143.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-213,455,636.52	-289,389,366.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	141,434,866.00	222,743,956.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-105,166,797.92	-119,809,929.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	166,611,533.00	346,313,259.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90,182,747.00	-119,509,081.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,989,409.33	120,794,509.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-48,904,224.00	-56,428,536.84
393	Биет бус хөрөнгө	234,829,000.00	234,575,500.00
39301	Програм хангамж	1,647,500.00	1,647,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,206,500.00	-1,460,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	234,388,000.00	234,388,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,381,610,214.33	1,656,513,722.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,381,610,214.33	1,656,513,722.01
51	Засгийн газрын хувь оролцоо	1,381,610,214.33	1,656,513,722.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	668,904,654.51	668,904,654.51
51101	Өмч: - төрийн	668,904,654.51	668,904,654.51
512	Хуримтлагдсан үр дүн	582,202,700.11	857,106,207.79
51210	Өмнөх үеийн үр дүн	582,202,700.11	582,202,700.11
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	274,903,507.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,502,859.71	130,502,859.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,381,610,214.33	1,656,513,722.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	550,175,475.00	270,531,816.00
120	Нийтлэг татварын бус орлого	550,175,475.00	270,531,816.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	550,175,475.00	270,531,816.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	550,175,475.00	270,531,816.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344,877,415.00	469,140,763.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,819,915.00	20,395,813.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,819,915.00	20,395,813.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,057,500.00	448,744,950.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,057,500.00	448,744,950.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	424,138,457.28	464,769,071.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	424,138,457.28	452,769,071.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,608,322.85	429,169,894.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,886,219.94	153,161,275.74
210101	Үндсэн цалин	138,864,819.94	128,063,709.70
210102	Нэмэгдэл	34,696,400.00	25,097,566.04
210105	Гэрээт ажлын хөлс	47,325,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,821,767.00	19,668,331.18
210201	Тэтгэврийн даатгал	20,986,267.00	13,657,477.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,208,900.00	1,407,290.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,767,100.00	1,228,384.62
210204	Ажилгүйдлийн даатгал	441,800.00	307,016.27
210205	Эрүүл мэндийн даатгал	4,417,700.00	3,068,162.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,350,116.00	32,371,717.00
210301	Гэрэл, цахилгаан	10,787,776.00	8,830,595.81
210302	Түлш, халаалт	21,875,640.00	23,442,521.19
210303	Цэвэр, бохир ус	686,700.00	98,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,078,229.63	23,122,600.00
210401	Бичиг хэрэг	2,521,300.00	1,422,900.00
210402	Тээвэр, шатахуун	13,833,500.00	19,552,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,099,229.63	1,037,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	580,000.00	1,109,600.00
210408	Бараа материал акталсны зардал	7,044,200.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	941,500.00	2,100,000.00
210604	Урсгал засвар	941,500.00	2,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,541,500.00	4,535,900.00
210702	Дотоод албан томилолт	2,541,500.00	4,535,900.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,677,288.00	56,080,862.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,377,481.00	54,472,399.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	461,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	579,104.00	517,938.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	119,928.00	197,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,311,702.28	138,129,208.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,246,100.00	10,448,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,987,602.28	127,681,008.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,530,134.43	23,599,176.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,739,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,184,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	555,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,530,134.43	18,859,876.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,530,134.43	18,859,876.55
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	12,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	12,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	12,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	470,914,432.72	274,903,507.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,504,166.60	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,504,166.60	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,504,166.60)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	469,410,266.12	274,903,507.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	344,877,415.00	469,140,763.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344,877,415.00	469,140,763.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,819,915.00	20,395,813.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,819,915.00	20,395,813.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	331,057,500.00	448,744,950.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	331,057,500.00	448,744,950.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	344,397,415.00	333,781,663.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,397,415.00	333,781,663.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,867,280.57	309,239,086.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,886,219.94	153,161,275.74
210101	Үндсэн цалин	138,864,819.94	128,063,709.70
210102	Нэмэгдэл	34,696,400.00	25,097,566.04
210105	Гэрээт ажлын хөлс	47,325,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,819,700.00	19,668,331.18
210201	Тэтгэврийн даатгал	20,984,200.00	13,657,477.45
210202	Тэтгэмжийн даатгал	2,208,900.00	1,407,290.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,767,100.00	1,228,384.62
210204	Ажилгүйдлийн даатгал	441,800.00	307,016.27
210205	Эрүүл мэндийн даатгал	4,417,700.00	3,068,162.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,254,916.00	34,499,917.00
210301	Гэрэл, цахилгаан	10,787,776.00	8,830,595.81
210302	Түлш, халаалт	23,828,540.00	24,936,121.19
210303	Цэвэр, бохир ус	638,600.00	733,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,898,629.63	14,708,532.00
210401	Бичиг хэрэг	2,701,300.00	1,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,576,600.00	8,762,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,402,229.63	1,401,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,218,500.00	3,194,982.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,101,500.00	3,300,000.00
210604	Урсгал засвар	1,101,500.00	3,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,541,500.00	4,535,900.00
210702	Дотоод албан томилолт	2,541,500.00	4,535,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,666,715.00	61,080,862.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,366,908.00	59,472,399.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	430,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	286,000.00	565,463.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	227,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	356,807.00	384,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,698,100.00	18,284,268.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,620,100.00	18,284,268.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,530,134.43	24,542,576.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,682,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,184,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,498,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,530,134.43	18,859,876.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,530,134.43	18,859,876.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	480,000.00	135,359,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	480,000.00	135,359,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	480,000.00	135,359,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	480,000.00	135,359,100.00
222001	Тоног төхөөрөмж	-	3,492,000.00
223001	Бусад хөрөнгө	-	12,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	480,000.00	119,867,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	112,792,434.0	912,199,948.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	61,505.9	61,505.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	112,853,939.9	912,261,454.1
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	469,410,266.1	469,410,266.1
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	582,202,700.1	1,381,610,214.3
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	582,202,700.1	1,381,610,214.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	582,202,700.1	1,381,610,214.3
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	274,903,507.7	274,903,507.7
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	668,904,654.5	130,502,859.7	857,106,207.8	1,656,513,722.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	327,301,700.00	296,960,618.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327,301,700.00	296,960,618.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,801,700.00	295,462,218.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,338,900.00	153,161,275.74
210101	Үндсэн цалин	141,175,900.00	128,063,709.70
210102	Нэмэгдэл	36,163,000.00	25,097,566.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,940,700.00	19,668,331.18
210201	Тэтгэврийн даатгал	16,847,200.00	13,657,477.45
210202	Тэтгэмжийн даатгал	1,773,400.00	1,407,290.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,418,700.00	1,228,384.62
210204	Ажилгүйдлийн даатгал	354,700.00	307,016.27
210205	Эрүүл мэндийн даатгал	3,546,700.00	3,068,162.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,338,200.00	34,499,917.00
210301	Гэрэл, цахилгаан	10,676,900.00	8,830,595.81
210302	Түлш, халаалт	24,922,500.00	24,936,121.19
210303	Цэвэр, бохир ус	738,800.00	733,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,230,600.00	14,222,532.00
210401	Бичиг хэрэг	1,350,000.00	1,350,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,276,600.00	8,276,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,404,000.00	1,401,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,194,982.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300,000.00	3,300,000.00
210604	Урсгал засвар	3,300,000.00	3,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,535,900.00	4,535,900.00
210702	Дотоод албан томилолт	4,535,900.00	4,535,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,117,400.00	61,080,862.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,472,400.00	59,472,399.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	586,000.00	565,463.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	227,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	384,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,993,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,993,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,498,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.00	1,498,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,498,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	136,512,000.00	135,359,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	136,512,000.00	135,359,100.00
222001	Тоног төхөөрөмж	66,512,000.00	65,429,100.00
223001	Бусад хөрөнгө	70,000,000.00	69,930,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	463,813,700.00	448,744,950.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	463,813,700.00	448,744,950.00
132001	Орон нутгийн төсвөөс	463,813,700.00	448,744,950.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,253,160.00	3,253,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,053,160.00	3,253,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,250.00	3,053,160.00
2104	Хангамж, бараа материалын зардал	107,250.00	107,250.00
210402	Тээвэр, шатахуун	213,750.00	107,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	213,750.00	213,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,732,160.00	213,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,732,160.00	2,732,160.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	2,732,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,326,750.00	200,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,326,750.00	3,326,750.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,326,750.00	3,326,750.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,326,750.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд 25 орон тооны бүтэцтэй, удирдах албан тушаалтан 3, гүйцэтгэх ажилтан 20, туслах ажилтан 2 орон тоотой ажиллаж байна.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

“АТАР IV” аяны хүрээнд Архуст сум тариалангийн бүс нутаг тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бодлогыг дэмжин ажиллаж 2022 онд 8,743.1 га-д тариалалт хийж 21,310.53 тн ургац хураан авсан байна.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 бүлэг, 10 зорилт, 79 дэд зорилттой, хавсралт 1-ээр "Зохион байгуулах сургалтын төлөвлөгөө", хавсралт 2-оор "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г баталсан байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тус байгууллага 78 ажлыг 100 хувь, 1 ажлыг 95 хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2022 оны 01 дугаар сарын 11-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалтын комисс"-ыг А/09 дугаар тушаалаар Санхүү албаны даргаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчилэн томилсон байна.

Архуст сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 8 зорилт 32 арга хэмжээний хүрээнд улирлаар төлөвлөн захиргаа, төсөв санхүү, албаны үйл ажиллагаанд хяналт хийж 2 чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд Санхүү хяналт, аудитын алба хяналт шалгалт хийж 8 зөвлөмж, 1 шаардлага хүргүүлсэн байна.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү төрийн сангийн хэлтсийн 2012 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү баримт бичигт төсвийн байгууллагын санхүү тайлагналын онцлогийг агуулсан бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 274,903.5 мянган төгрөгөөр буюу 19,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	41,661.7	68,453.3	26,791.6
Үндсэн хөрөнгө	1,339,948.5	1,588,060.5	248,111.9
Нийт хөрөнгө	1,381,610.2	1,656,513.7	274,903.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,381,610.2	1,656,513.7	274,903.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,381,610.2	1,656,513.7	274,903.5

Бараа материал дансны хувьд сэлбэг хэрэгсэл 2,600,000.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1,493,600.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 22,698,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2022 онд барилга байгууламж, орон сууц 63,977.0 мянган төгрөг, тээврийн хэсэгсэл 81,309.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 179,702.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 41,900.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 28,000.0 мянган төгрөгийн тээврийн хэсэгсэл, 38,012.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 11,955.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 22,077.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 53,309.0 мянган төгрөгийн тээврийн хэсэгсэл, 141,690.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 141,690.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,656,514.0 мянган төгрөг болж 274,904.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 463,813.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэсээс төсвийн төслөөс бууруулахгүйгээр 463,813.7 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна. Үүнд: цалин хөлс, НДШ-ийн зардалд 201,279.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 36,338.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 14,230.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 3,300.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 61,117.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,000.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгт 1,500.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 136,512.0 мянган төгрөгийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 104 арга хэмжээг санхүүжүүлэхээр Орон нутгийн төсвөөс 463,813.7 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 449,078,9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 16,425.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 448,744.9 мянган төгрөг буюу 96,8 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 28,450,0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,838.3 мянган төгрөг, хөрөнгийн зардал 1,152.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	219,353.4	195,103.6	24,249.8	88.9
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	54,472.4	54,472.4	0.0	100
3	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны ҮАЗардал	38,775.9	32,697.8	6,078.0	100
4	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,500.0	1,500.0	0	100
5	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	136,512.0	135,359.1	1,152.9	99.2
6	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,993.4	6,600.0	99.9
7	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100
8	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдол	3,200.0	3,194.9	5,018.0	99.8
	Дүн	463,813.7	1,527,444.8	42,830.2	90.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд усны нөхөн төлбөр 2,189.6 мянган төгрөг, ХАА-н тооллого судалгааны санхүүжилт 3,224.9 мянган төгрөг, халдварт өвчний шатахуун үнэ 486.0 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн ажлаас чөлөөлөгдсөн тэтгэмж 4,184.3 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 10,000.0 мянган төгрөг, зуучлалын болон хураамжийн орлого 311.0 мянган төгрөг, нийт 20,395.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар тээвэр шатахуунд 5,898.9 мянган төгрөг, ажлаас халагдсаны тэтгэмжид 4,184.3 мянган төгрөг, тооллогод 1,630.2 мянган төгрөг, хивэг тэжээлд 3,600.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2,647.8 мянган төгрөг зарцуулж, 2,434.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	ОН өөрөө удирдах байгууллага	ОН өөрөө удирдах байгууллага хөтөлбөр 90,7%	461,513.7	446,444.9
2	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлагаар хангах	Хөдөө аж ахуй газар тариалан аж үйлдвэрийн бодлого удирдлагаар хангах хөтөлбөр 96,20%	2,300.0	2,300.0

Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газар Орон нутгийн өөрөө удирдах хөтөлбөр 90,7% буюу 9,3%-иар дутуу хэрэгжсэн нь орон тоо бүтэц 19-20 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж 4 орон тоо дутуу байсанаас шалтгаалсан байна. Орон тоо бүтэц дутуу ажилласан нь төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 895,052.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,425.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,740.6 мянган төгрөгөөр тогтоосныг тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ нь тайлант онд төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд байр ашиглалтай холбоотой тогтмол зардал 1,838.3 бусдаар хөрөнгийн зардал 1,152.9 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 12 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 9 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 5.0 сая төгрөгөөс дээш 24,147.7 мянган төгрөгийн 2 гүйлгээг нийт 34 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим"-ыг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн, явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон. Завсрын аудитаар анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 7,572.0 мянган төгрөг, төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 210.0 мянган төгрөг, авлагатай холбоотой 1,093.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/64 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	43,562.8	2	43,562.8	66.6
Зөвлөмж	2	919.8	2	919.8	100
Нийт дүн	5	44,482.6	5	44,482.6	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын бараа материалын бүртгэл, зарцуулалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 11,606.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.Үүнд:

Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 11,606.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 216,134.4 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² 153,251.5 мянган төгрөгийн зөвлөмж, 62,882.9 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.2 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн 38,735.2 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

Саммит компьютер технологи ХХК-иас 24,147.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 153,251.5 мянган төгрөгийн өртгөтэй 1075 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 11,606.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна	1	11,606.0			1	11,606.0	1	11,606.0
Дүн	1	11,606.0			1	11,606.0	1	11,606.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	38,735.2	-	38,735.2	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 153,251.5 мянган төгрөгийн өртгөтэй 1075 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	153,251.5	-	-	153,251.5
Саммит компьютер технологи ХХК-иас 24,147.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийсэн байна	24,147.7	-	24,147.7	-
Дүн	216,134.4	-	62,882.9	153,251.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 12 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 9 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 24,147.7 мянган төгрөгийн 2 гүйлгээг нийт 34 мэдээллийг хугацаа хоцроосон байна	24,147.7	-	24,147.7	-